



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 30 өдөр

Дугаар А/491

Ховд

Хөрөнгө гаргах тухай

Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2018 оны “Аймгийн 2019 оны төсөв батлах тухай” 8/04 дүгээр тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Аймгийн залуучуудын анхдугаар урлаг, спортын фестиваль наадмын арга хэмжээний зардлын төсвийг 26.4 сая төгрөгөөр хавсралтаар баталж зарцуулсугай.

2.Дээрх арга хэмжээнд зарцуулах 26.4 сая төгрөг /Хорин зургаан сая дөрвөн зуун мянган/-ийг Орон нутгийн хөгжлийн сангийн төсөл, хөтөлбөр арга хэмжээний 5.25 дахь Залуучуудын хөгжлийг дэмжих хөтөлбөрийн зардлаас гаргахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга /Ч.Багдал/, Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч /Ц.Ганданповрон/ нарт зөвшөөрсүгэй.

3.Тус арга хэмжээний хэрэгжилтэнд хяналт тавьж үр дүнг аймгийн Засаг даргын зөвлөлд тайлагнахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА

Б.ДҮГЭРЖАВ

